

ТОСТ БОРЖИГОНЫ ТОРГОН ХОЙМОР

Газар зохион байгуулалтын хүрээнд хийгдсэн ажил

1. Газар өмчлөлийг эрчимжүүлэх ажил

2016 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ИТХ-аар 2017 оны Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг хэлэлцүүлэн баталсан. Тухайн төлөвлөгөөгөөр сумын хэмжээнд 154 иргэнд газар өмчлүүлэхээр тусгагдсан.

Үүнд:

- Сүлд гэр хороололд 14 иргэнд
- Лүн гэр хороололд 100 иргэнд
- 16-р зөрлөгт 40 иргэнд

➤ 2017 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн А/36 тоот захирамжаар 16-р зөрлөг, Сүлд гэр хороололд газар өмчлөх хүсэлт гаргасан 54 иргэний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн.


➤ 2017 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн А/47 тоот захирамжаар Лүн гэр хороололд газар өмчлөх хүсэлт гаргасан 77 иргэний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн.

➤ 2017 оны 09 дүгээр сарын 22 – ны өдрийн А/57 тоот захирамжаар Лүн гэр хороололд газар өмчлөх хүсэлт гаргасан 23 иргэний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн.

Газар өмчлөлийн байдал /2015-2017/

Он	Өмчилсөн иргэдийн тоо	Сумын тухайн жилийн нийт өрх	Нийт өрхөд харьцуулсан хувь	Сумын тухайн жилийн хүн ам	Сумын нийт хүн амд харьцуулсан хувь
2015	1153	361	319,4	1153	100,0
2016	1245	387	321,7	1204	103,4
2017	1371	417	384	1240	114,6

Газар өмчилсөн иргэд



ТОСТ БОРЖИГОНЫ ТОРГОН ХОЙМОР

Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, гэрчилгээг шинэчлэх ажлын хүрээнд 2015-2016 онуудад хороо бууцны газар эзэмших эрхтэй иргэдийн гэрчилгээг хураан авсан. Гэрчилгээг шинэчлэх ажлыг 2017 оны 1 дүгээр сараас эхлүүлж нийт 20 иргэний гэрчилгээг шинэчлэн хороо бууцны цэг аван мэдээллийн санд оруулсан байна.

5. Сумын геодезийн цэг тэмдэгтийн тооллогын ажил

Баянтал суманд төвийн 5, хөдөө 10 нийт 15 цэг тэмдэгтийг тооллоо. Тооллогын явцад GR022 дугаартай цэг, Хө.Рп 022 дугаартай цэгтэй давхцсан, Тал гэсэн цэгийн дугаартай цэг сүлд овооны доор буусан сүлд овоо дээр нь барьсан цэгийн мэдээлэл дугаар харагдахааргүй болсон. ПЦ- 3119 дугаартай цэгийг 2015 онд Эм Жи Си энженерги ХХК нөхөн сэргээн суулгаж БХБТГ- 9031 дугаартай цэгээр нөхөн сэргээсэн байна.



6. Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажил

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Газрын харилцаа, Геодези зураг зүйн газрын даргын баталсан “Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх журам, заавар”-ын дагуу 2017 оны 8 дугаар сарын 01-ний өдөр сумын 1,2 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах бэлчээр ашиглалтын 5хэсэг тус бүрээс 2 цэг авч нийт 10 цэг дээр фотомониторинг хийж ургамлын дээж аван Sample point программ хангамж ашиглан боловсруулалт хийж гүйцэтгэсэн.



7. Нээлттэй хаалганы өдөрлөг

Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг Баянтал суманд 2017.06.07-ны өдөр зохион

ТОСТ БОРЖИГОНЫ ТОРГОН ХОЙМОР

байгуулж иргэдэд газар өмчлөлийн байдал болон ГХБХБГ-аас зохион байгуулж буй томоохон ажлууд, хөрөнгө оруулалтын ажлууд, мөн Баянтал сумын 2017 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг тоон болон зурган хэлбэрээр танилцуулж мэдээлэл хүргэхээс гадна гарын авлага материал тараалаа. Өдөрлөгт газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүд болон сумын газрын даамал Б.Батчимэг, улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн улсын бүртгэгч Т.Цэвэлмаа нар оролцож нийт 43 иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласан. Үүнд:

- Газрын кадастрын зургаар - 2 иргэнд
- Газар хэмжилт – 10 иргэнд
- Газар өмчлөх өргөдөл – 5 иргэн
- Өмчилсөн газраа баталгаажуулж үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авсан – 10 иргэн
- Газар өмчлөх эрх шилжүүлэх гэрээг- 1 иргэнд
- Газар өмчлөх материал -6 иргэнд хүлээлгэн өгөхөөс гадна гарын авлага материал тарааж, газар өмчлөх өргөдөл хэрхэн бүрдүүлж өгөх, эрх шилжүүлэх гэрээ хийх зэрэг зөвлөгөө үйлчилгээг иргэдэд хүргэж ажилласан.



Малчин өрхөөр явж санал хүсэлтийг сонсох

ИТХ-ын даргаар ахлуулсан ажлын хэсэг буюу МЭҮТ-ийн мэргэжилтэн, их эмч, 2 дугаар багийн засаг дарга, газрын даамал зэрэг бүрэлдэхүүнтэй 2017.08.23-ны өдрөөс эхлэн 2017.08.25-ны хооронд 3 өдөр малчин өрхүүдээр явж ажиллалаа. Айл өрхүүдээр явахдаа өвөлжөө, хаваржааны газартай холбоотой болон өмчлөлийн газартай холбоотой асуудлуудтай танилцан шийдвэрлэн мэдээ мэдээлэл өгч ажиллалаа. Үүнд хороо бууцны асуудалтай гэрчилгээ шинэчлүүлэхээр хураалган, буцааж аваагүй 11 иргэнд гэрчилгээ шинэчлэн олгоход бүрдүүлэх бичиг баримт болон бусад мэдээ мэдээллийг өгсөн ба үүнээс 1 иргэний гэрээ гэрчилгээг шинэчлэн олгож бусад иргэнийг ойрын хугацаанд ирж гэрээ гэрчилгээгээ шинэчлүүлэн авах тухай зөвлөмж хэлсэн. Өмчлөлийн газартаа хэрхэн хэмжилт хийлгэх талаар 3 иргэнд мэдээлэл өгсөн. Шинээр хороо бууцтай болох тухай 3 иргэний хүсэлтэд энэ жилийн хороо бууцны өргөдөл хүлээн аваад дууссан тул ирэх онд өргөдлөө өгөх боломжтой гэж зөвлөсөн. Бусад иргэд газартай холбоотой асуудал маргаан гараагүй байна.

ТОСТ БОРЖИГОНЫ ТОРГОН ХОЙМОР

Газрын цахим мэдээллийн сан “ЛЭНД МЕНЕЖЕР” програмд нэвтрэх

Засгийн газрын 2009 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн дугаар 25-р тогтоол Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэж байгаа геодезийн байрлалын сүлжээний хэмжилт, боловсруулалтын ажилд олон улсын геодезийн “WGS-84” солбилцлыг, өндрийн сүлжээнд Балтийн тэнгисийн тогтолцоог, том, дунд, масштабын байр зүйн зураглалд дэлхийн хөндлөн меркаторын “UTM” тусгагийг хэрэглэх тухай тогтоол гарсан. Тус тогтоолын хэрэгжилтийг ханган Лэнд менежер програм хангамжийн сургалтанд 2 удаа хамрагдаж 2017 оны 6 дугаар сараас эхлэн суманд нэвтрүүлсэн. Лэнд менежер програм хангамжинд өмчлөлийн газрын 154 иргэн, эзэмшлийн газрын 20 иргэн, 3 аж ахуй нэгж байгууллагын нөхөн бүрдүүлэлтийг хийж хувийн хэргийн материалыг олшруулан цахим мэдээллийн сан үүсгэн ажилласан.

